

ТҮЛХҮҮР:

Халамцуухан мазаалай-1

№	Асуулт даалгавар	Зөв хариулт	Оноо	Нэмэлт тайлбар
1	Эхээс мазаалай устаж цөөрөхөд нөлөөлж буйг гэрчлэх баримтыг түүж, 40-50 үгэнд багтаан хамгаалах гарцыг санал болгон бичээрэй.	<ul style="list-style-type: none"> - өлбөрч үхэх - хатаж үхэх - бие биенээ хороох - үр төлөө эс тоох гэх зэрэг 	10	<ul style="list-style-type: none"> ➤ 4 ба түүнээс дээш санаа гаргасан бол 10оноо ➤ 3 санаа гаргасан бол 7 оноо ➤ 2 санаа гаргасан бол 4 оноо ➤ 1 санаа гаргасан бол 2 оноо <p>Юу ч бичээгүй бол 0 оноо Аль нэгийг нь хариулсан тохиолдолд оноог өгнө.</p>
2	Мазаалайн ядарч зүдэрчбайгаа шалтгаан юу вэ?	<ul style="list-style-type: none"> - Говийн байнгын үзэгдэл их ган ус булгийг ширгээдэг - Зарим жил тэндхийн хөрснөөс зээргэнэ ч цухуйхгүй 	4	<ul style="list-style-type: none"> ♦ 2 санааг хоёуланг нь гаргасан бол 4 оноо ♦ Аль нэгийг нь орхигдуулсан бол 2 оноо ♦ Оновчгүй хариулсан бол 0 оноо
3	Эхэд байгаа доорх үг хэллэгийн утгыг тайлбарланауу.	<ul style="list-style-type: none"> - ноохой – ичээний амьтны хэвтэш - умартах – мартаг, санахгүй байх 	4	<ul style="list-style-type: none"> ➤ Дурдсан санааг бүгдийг гаргасан бол 4 оноо ➤ Аль нэг санааг орхигдуулсан бол 2 оноо ➤ Оновчгүй бол 0 оноо
4	Дараах 3 энгийн өгүүлбэрийн байрыг сэлгэн холбож, холимог нийлмэл өгүүлбэр бүтээгээрэй.	Хайр сэтгэлийг зөвхөн цэцэгсийн хэлээр л төгс илэрхийлж болдог учраас цэцгийн энэ нууц хэлийг мартахаараа хүн хайрлаж, дурлаж чадахаа болих ба хайрлаж дурлаж үзээгүй хүн тэр хэлийг эс мэднэ. Гм -	4	<ul style="list-style-type: none"> ➤ Оновчтой бүтээврээр тайлбарласан бол 4 оноо ➤ тайлбар дутмаг бол 0 оноо
5	Алдаатай үгийг засаж, ЗБДүрмээр тайлбарлаарай.	<ul style="list-style-type: none"> ➤ Дацангын- Дацангийн ➤ Хоолойн Г араас ямагт –ий бичнэ. 	2	<ul style="list-style-type: none"> ➤ Алдаатай үгийг зөв засаж, дүрмийг тайлбарласан бол 2 оноо ➤ Алдаатай үгийг зөв засаж, дүрмийг тайлбарлах 2-ын аль нэгийг хийсэн бол 1 оноо ➤ Огт бичээгүй бол 0 оноо ➤ Буруу бичсэн бол Х

6	Алдаатай үгийг засаж, ЗБДүрмээр тайлбарлаарай.	-Дийлхээргүй- Дийлэхээргүй Үйл үгийн Х-ийн өмнөх балархай эгшгийг гээхгүй бичнэ.	2	<ul style="list-style-type: none"> ➤ Алдаатай үгийг зөв засаж, дүрмийг тайлбарласан бол 2 оноо ➤ Алдаатай үгийг зөв засаж, дүрмийг тайлбарлах 2-ын аль нэгийг хийсэн бол 1 оноо ➤ Огт бичээгүй бол 0 оноо ➤ Буруу бичсэн бол Х
7	Эдип хаан юуны төлөө санаа зовсон тухай болон түүний шийдвэрийн талаар үзэл бодлоо бичнэ үү. Үзэл бодлоо илэрхийлэхдээ юунаас үндэслэсэнээ бичээрэй	➤ Эцгээ алж, эхийгээ эзэгнэсэн	2	<ul style="list-style-type: none"> ➤ Санааг гүйцэт гаргасан бол 2 оноо ➤ Санааг дутуу гаргасан бол 1 оноо ➤ Огт бичээгүй бол 0 оноо
8	Б. Лхагвасүрэн “Боржгины бор тал” шүлэгт “Эхийн сүү тагнайд амтагдаж...” гэсэн нь ямар утгатай вэ?	А. Ээж минь үгүйлэн бодогдсон	2	<ul style="list-style-type: none"> ➤ Зөв хариултыг дугуйлсан тохиолдолд 2 оноо ➤ Буруу хариулт буюу дугуйлаагүй тохиолдолд 0 оноо
9	“Сүүлчийн хичээл” өгүүллэгийн товч агуулгыг бичээрэй.			<ul style="list-style-type: none"> ➤ Агуулгаас хамааран 1-5 оноо өгнө. ➤ Огт бичээгүй бол 0 оноо
7	Үндэсний бичгээс кирил бичигт хөрвүүлээрэй.	Тамирын голын мөсөн дээр үдшийн одод мөнгөн аяга шиг жингэнэн унана. Зарим нь хагарчихав уу гэлтэй тас нис хийнэ. Сарны туяа үзэсгэлэнтэй сайхан ажээ.	5	<ul style="list-style-type: none"> ➤ 0 – 1 алдвал 5 оноо ➤ 2 – 4 алдвал 4 оноо ➤ 5 – 6 алдвал 3 оноо ➤ 7 – 8 алдвал 2 оноо ➤ 9 – 11 алдвал 1 оноо ➤ 12, түүнээс дээш алдвал 0 оноо

ТҮЛХҮҮР:

ЭНДРЮС ЮУ ОЛОВ? -1

№	Асуулт даалгавар	Зөв хариулт	Оноо	Нэмэлт тайлбар
1	.Эндрюсийн экспедици малтлага хийсний үр дүнд юуг нээсэн бэ?	- Р.Эндрюсийн экспедиц тэр жилээ өнөөгийн Баянхонгор аймгийн нутаг Бөөнцагаан нуур, Өөшийн нуруу, Луугийн худаг, Арц богд, Баян заг зэрэг газар малтлага хийж хирс маягийн аварга (Baluchitherium) гүрвэл тоть хошууг үлэг гүрвэл (Psittacosuar protiguanoddon) зэргийг олжээ. - 1923 онд төв азийн гуравдугаар экспедицийнхэн палеонтологич Жорж Оулсоны олсон үлэг гүрвэлийн өндөг байв. - Энэ цаг мөчөөс хойш хүн төрөлхтөн үлэг гүрвэл өндөг гаргадгийг мэдсэн. - Мөн шүдгүй махан идэшт гүрвэлийг ч эндээс олж нээсэн байна. Овираптор (Oviraptor) нь шүдгүй боловч бусад үлэг гүрвэлийнхээ өндгийг хулгайлан иддэг амьтан байжээ.	10	<ul style="list-style-type: none"> ➤ 4 ба түүнээс дээш санаа гаргасан бол 10оноо ➤ 3 санаа гаргасан бол 7 оноо ➤ 2 санаа гаргасан бол 4 оноо ➤ 1 санаа гаргасан бол 2 оноо <p>Юу ч бичээгүй бол 0 оноо Аль нэгийг нь хариулсан тохиолдолд оноог өгнө.</p>
2	Цогт Бадамжав, Эндрюсийн III экспедицид ажиллах болсон шалтгаан юу вэ?	- Өмнө нь Ноён уулын архелогийн судалгааг амжилттай хийсэн - Козловын экспедицид ажиллаж байсан туршлагатай	4	<ul style="list-style-type: none"> ♦ 2 санааг хоёуланг нь гаргасан бол 4 оноо ♦ Аль нэгийг нь орхигдуулсан бол 2 оноо ♦ Оновчгүй хариулсан бол 0 оноо
3	Эхэд байгаа доорх үгстэй ойролцоо утгат үг хэллэгийг олго уу	Ширдэг - дэвсгэр, хивс, олбог - Зарлах - мэдээлэх, тунхаглах	4	<ul style="list-style-type: none"> ➤ Дурдсан санааг бүгдийг гаргасан бол 4 оноо ➤ Аль нэг санааг орхигдуулсан бол 2 оноо ➤ Оновчгүй бол 0 оноо

4	Дараах 3 энгийн өгүүлбэрийн байрыг сэлгэн холбож, холимог нийлмэл өгүүлбэр бүтээгээрэй.	Хайр сэтгэлийг зөвхөн цэцэгсийн хэлээр л төгс илэрхийлж болдог учраас цэцгийн энэ нууц хэлийг мартахаараа хүн хайрлаж, дурлаж чадахаа болих ба хайрлаж дурлаж үзээгүй хүн тэр хэлийг эс мэднэ. Гм -	4	<ul style="list-style-type: none"> ➤ Оновчтой бүтээврээр тайлбарласан бол 4 оноо ➤ тайлбар дутмаг бол 0 оноо
5	Алдаатай үгийг засаж, ЗБДүрмээр тайлбарлаарай.	<ul style="list-style-type: none"> ➤ Зурагын- Зургийн ➤ Хоолойн Г араас ямагт –ий бичнэ. 	2	<ul style="list-style-type: none"> ➤ Алдаатай үгийг зөв засаж, дүрмийг тайлбарласан бол 2 оноо ➤ Алдаатай үгийг зөв засаж, дүрмийг тайлбарлах 2-ын аль нэгийг хийсэн бол 1 оноо ➤ Огт бичээгүй бол 0 оноо ➤ Буруу бичсэн бол Х
6	Алдаатай үгийг засаж, ЗБДүрмээр тайлбарлаарай.	-Барилдхааргүй- Барилдахааргүй Үйл үгийн Х-ийн өмнөх балархай эгшгийг гээхгүй бичнэ.	2	<ul style="list-style-type: none"> ➤ Алдаатай үгийг зөв засаж, дүрмийг тайлбарласан бол 2 оноо ➤ Алдаатай үгийг зөв засаж, дүрмийг тайлбарлах 2-ын аль нэгийг хийсэн бол 1 оноо ➤ Огт бичээгүй бол 0 оноо ➤ Буруу бичсэн бол Х
7	Эдип хаан юуны төлөө санаа зовсон тухай болон түүний шийдвэрийн талаар үзэл бодлоо бичнэ үү. Үзэл бодлоо илэрхийлэхдээ юунаас үндэслэсэнээ бичээрэй	➤ Эцгээ алж, эхийгээ эзэгнэсэн	2	<ul style="list-style-type: none"> ➤ Санааг гүйцэт гаргасан бол 2 оноо ➤ Санааг дутуу гаргасан бол 1 оноо ➤ Огт бичээгүй бол 0 оноо
8	Б. Лхагвасүрэн “Боржгины бор тал” шүлэгт “Эхийн сүү тагнайд амтагдаж...” гэсэн нь ямар утгатай вэ?	А. Ээж минь үгүйлэн бодогдсон	2	<ul style="list-style-type: none"> ➤ Зөв хариултыг дугуйлсан тохиолдолд 2 оноо ➤ Буруу хариулт буюу дугуйлаагүй тохиолдолд 0 оноо

9	“Хамелеон” өгүүллэгийн товч агуулгыг бичээрэй.		5	<ul style="list-style-type: none"> ➤ Агуулгаас хамааран 1-5 оноо өгнө. ➤ Огт бичээгүй бол 0 оноо
7	Үндэсний бичгээс кирил бичигт хөрвүүлээрэй.	<p>Тооноор сар гэрэлтэх сайхан Тогоотой сүүн дээр тусах сайхан Шөнө орой сар гарах сайхан Чөдөртэй морьд тургилах сайхан</p>	5	<ul style="list-style-type: none"> ➤ 0 – 1 алдвал 5 оноо ➤ 2 – 4 алдвал 4 оноо ➤ 5 – 6 алдвал 3 оноо ➤ 7 – 8 алдвал 2 оноо ➤ 9 – 11 алдвал 1 оноо ➤ 12, түүнээс дээш алдвал 0 оноо

11 АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН
ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ -2024

11а ангийн сурагч

Хугацаа 80минут

Нийт 40 оноо

Эхийг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

“Халамцуухан мазаалай” Ахувилбар

Мазаалай нь говь цөлд амьдардаг дэлхийн цорын ганц баавгай бөгөөд зөвхөн Монголын говьд байдаг байна. Мазаалайн эм нь эвш, бамбарууш нь алманцаг гэсэн сонин нэртэй. Хоёр жил болж байж төрдөг. Тэгэхдээ голдуу ихэрлэдэг юм гэсэн. Агуй хонгил, хулсан ширэнгэ, сухайн төгөл доогуур үүр ноохойгоо засна. Өвөл тэндээ ичдэг. Сүүдэр олохгүй бол хулс зэгс овоолж овоохой босгочихдог. Өдрийн халууныг овоохойдоо хэвтэн өнгөрөөж, үдшээс үүр цайтал гөрөөлнө. Мазаалай устаж байгаа амьтан. Шүднээсээ олонгүй баавгай үлдсэн гэж эрдэмтэд тооцоолжээ. Мазаалайн тоо толгой цөөн боловч ургамлын гаралтай идэш тэжээлээр зонхилон хооллож, жижиг баянбүрдийг түшиж амьдардаг нь экосистемд чухал ач холбогдолтой. Хөхтөн амьтдын сэг зэмээр хооллодог тул байгальд ариутгагчийн үүрэг гүйцэтгэхээс гадна хөрсний ус ойр газар малтаж ус гаргадаг учир хавтгай зэрэг говийн бусад хөхтөн амьтдыг усаар хангахад чухал үүрэгтэй.

Говийн байнгын үзэгдэл их ган ундаалдаг ус булгийг нь ширгээдэг. Тэр ангаж үхнэ. Зарим жил тэндхийн хөрснөөс зээргэнэ ч цухуйхгүй. Тэр яс мэрсээр байгаад өлбөрч үхдэг. Тэд ийнхүү ядарч зүдэрч амьдарч байгаа билээ. Гэвч уруудах тутам нүүрээ буруулдаг нь орчлонгийн жам. Мазаалай амьдрахад улам л хүнд болсоор байгаа мэт санагдана. Ядахдаа хэдий чинээ цөөрнө, тэдний доторх тэнэгийн тоо төдий чиний өсдөг нь бүр харамсалтай. Мазаалай цөөхөн. Тийм атлаа говьд хааяа нэг тааралдахаараа бие биеэ барьж иднэ гээч. Салгалалдан архиралдаж бие биенээ айлгах гэж байдгаараа ярзайлдан орилолддог. Тэгээд л ноцолдчихно. Нэг нь дийлж, нөгөөдөх нь дийлдэх нь мэдээж. Дийлдсэн нь биеэ суллан сарвуугаа өргөн гөлөлзөж бууж өгдөг. Яг энэ мөчид уг амьтдад байгалиас заяасан нэг хууль үйлчлэх ёстой юм. Бууж өгснийгөө өршөөж захиргаандаа авах. Махчид ихэвчлэн хүзүүгээ тавьж бууж өгдөг. Мазаалай ч мөн тэгнэ. (Амьтдыг ядахдаа л өөрсдөөр нь хороолгохгүй байя гэхдээ л энэ шүү дээ.) Гэвч энэ хууль мазаалайд хамаагүй. Тэд бууж өгснийгөө алж байж санаа нь амардаг. Алаад зогсохгүй гэдэс дотрыг нь гаргаж иддэг гэсэн. Үлдсэнийг нь хуршааж өмхийрүүлж идэхээр зэгсээр булж орхидог аж. Гэвч нэгэнт цадсан тул түүнийгээ умартан өөр тийшээ тэнэн алга болчихно. Уруудахад бурууддагийн нэг жишээ энэ. Бас эм баавгай үр зулзагандаа хатуурхана гэж жигтэйхэн. Алманцага хоосон хаячхаад хэдэн хоногоор хамаагүй тэнээд алга болчихно. Явж явж ирээд зулзагаа хөхүүлнэ гэж байхгүй. Салтаандаа хөхөө дараад суучихна. Алманцаг хэчнээн орилсон ч аргадахгүй, харин алгадаж унагадаг аж. Хөөрхий, хүүхэд нь нойрон дунд нь хулгайгаар мөөм үлгэнэ. Шувуун дэлэнт эхэд сүү байхгүй. Өөрөө үргэлж өлөн явах юм чинь юугаараа ч сүүшхэв.

Говийн баавгай их унтамхай. Тэгэхээс ч аргагүй. Цөлийн мансуурсан халуунд өөр юу ч хийх билээ? Их ган нүүрлэж, идэш тэжээлгүй болбол зунаар ичээлнэ. “Уруудахад унтаж идэх” гэж хүмүүс бие биеэ хэлдэг. Энэ үг баавгайд ч тохирмоор санагдана. Мазаалай намар болохоор хармагийн жимс их иднэ. Говийн жимс тун исгэлэн. Бараг мөчир дээрээ бэлэн болчихсон дарс л гэсэн үг. Мазаалай өлөн элгэн дээрээ хармаг идсээр байгаад согтчихдог байна. Согтуурч мансуурах нь сайхан мэт “санагдах” тул хүн архинд ордогтой адил хармагт орчихно. Тэр мөнхийн

согтуу найгана. Үе үехэн энэхүү одой баавгай хоёр гараараа цээжээ уран овоохойгоо тойрон гүйж яваа харагддаг гэнэ. Говийн анчид дурандаж “Энэ жил хармаг их гарч дээ, мазаалай согтчихож” гэж ярилцдаг аж. Халамцуу мазаалай тархиа шааж, өөрөө өөртөө агсам тавина. Бас нохой харвал чулуу шидэж дөвчигнөнө. Тэгснээ учиргүй их орилж хүүхэд шиг уйлдаг аж. Элчилгүй их элсэн цөлд балран сөнөж буй тавиландаа бачимдан давчиддаг ч байж мэдэх юм. Говьд байгаа бүхнийг зөвхөн сөнөх тавилан хүлээж байдаг нь аймшигтай шүү.

Ж.МЯГМАРСҮРЭН

1.Эхээс мазаалай устаж цөөрөхөд нөлөөлж буйг гэрчлэх баримтыг түүж, 40-50 үгэнд багтаан хамгаалах гарцыг санал болгон бичээрэй./10оноо/

.....
.....
.....
.....
.....
.....

2. Мазаалайн ядарч зүдэрч байгаа шалтгаан юу вэ? /4оноо/

.....
.....
.....
.....

3. Эхэд байгаа доорх үг хэллэгийн утгыг тайлбарлана уу. / 4 оноо /

ноохой -
умартах -

4. Дараах 3 энгийн өгүүлбэрийн байрыг сэлгэн холбож, холимог нийлмэл өгүүлбэр бүтээгээрэй. /4 оноо /

Хайр сэтгэлийг зөвхөн цэцэгсийн хэлээр л төгс илэрхийлж болдог. Хайрлаж дурлаж үзээгүй хүн тэр хэлийг эс мэднэ. Цэцгийн энэ нууц хэлийг мартахаараа хүн хайрлаж, дурлаж чадахаа больдог.

.....
.....
.....

5.Алдаатай үгийг засаж, ЗБДүрмээр тайлбарлаарай. /2оноо/

Дацангын-.....
.....

6. Алдаатай үгийг засаж, ЗБДүрмээр тайлбарлаарай./2оноо/

Дийлхээргүй-.....
.....

7. Эдип хаан юуны төлөө санаа зовсон тухай болон түүний шийдвэрийн талаар үзэл бодлоо бичнэ үү. Үзэл бодлоо илэрхийлэхдээ юунаас үндэслэснээ бичээрэй . /2оноо/

.....
.....
.....
.....

8. Б. Лхагвасүрэн “Боржгины бор тал” шүлэгт “Эхийн сүү тагнайд амтагдаж...” гэсэн нь ямар утгатай вэ? /2оноо/

- A. Ээж минь үгүйлэн бодогдсон
- B. Бага балчир насаа дурссан
- C. Ач тусыг нь санасан
- D. Элэг бүтэн амьдралыг үгүйлсэн
- E. Эхийн сүүг юугаар ч орлуулшгүй

9. “Сүүлчийн хичээл” өгүүллэгийн товч агуулгыг бичээрэй. /5оноо/

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

10. Үндэсний бичгээс крилл бичигрүү буулгаарай.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Fone% t. Jeri^ NI
Si (Jiekkune
Moiekkа Feye) t
Foidesi ia fodooa
Moisoa Деке*Г
Demi* oa Goo& oa

11 АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН
ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ -2024

11а ангийн сурагч

Хугацаа 80минут

Нийт 40 оноо

Эхийг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

ЭНДРЮС ЮУ ОЛОВ? Б Хувилбар

Нэгэн үе дэлхийг донсолгож байгаад нам гүм болж, ХХ зууны эх гэхэд бараг мартагдсан монголын нэрийг хорвоо ертөнцөд дахин сонсгосон нэгэн үйл явдал бол манай говиос олдсон палеонтологийн ховор чухал олдворууд юм. Тал нутгийн нүүдэлчид хур бороо, салхинд идэгдсэн эрэг гуу, жалганаас аварга том амьтны яс гарч ирэхийг нэг бус удаа хардаг байсан бөгөөд түүнийг дорно дахины ард түмний дунд түгээмэл байдаг домгийн амьтан болох лууны яс гэж үздэг байлаа. Өдгөө говийн сумдын орон нутгийн судлах музейд палеонтологийн ховор нандин үзмэр бүхий тасаг байх нь элбэг.

Чухамхүү тэдгээрийн эрт дээр цагт манай гараг дээр амьдарч байгаад мөхсөн үлэг гүрвэлийнх болохыг тогтоож, палеонтологийн ухааныг баяжуулсан хүн бол америкийн эрдэмтэн Рой Чэпмэн Эндрюс билээ. Тэрээр монголд ирэхээсээ өмнө Америкийн байгалийн түүхийн музейгээс зохион байгуулсан төв Азийн нэг, хоёрдугаар экспедицийг удирдаж байсан. Хятадын зарим муж, Өвөр монголд ажиллан баялаг туршлага хуримтлуулсан судлаач байв. Төв Азийн гуравдугаар экспедиц 1922 оны хавар тэр үед зөвлөлтийн нөлөөн дор хувьсгал хийж тусгаар тогтнолоо зарлаад байсан Монголын нийслэл болох Нийслэл хүрээг зорьжээ. Төв Азийн гуравдугаар экспедицийн удирдагч Р.Ч.Эндрюс 1922 оны тавдугаар сард тэр үеийн монгол улсын удирдагчид ба одоогийн шинжлэх ухааны академийн үндэс болох Судар бичгийн хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээ байгуулжээ. Монголын засгийн газар Судар бичгийн хүрээлэнг төлөөлөв. Цогт Бадамжав хэмээх хүн тэдэнтэй хамтран ажиллах болжээ. Энэ хүн өмнө нь Ноён ууланд археологийн малтлага амжилттай хийсэн.

Козловын экспедицид ажиллаж байсан туршлагатай нэгэн ажээ. Ноён уулнаас Хүннү нарын түүхэд холбогдох ширдэг, ваар сав зэрэг ховор олдвор гарсны зарим нь өдгөө ч Улаанбаатар дахь үндэсний түүхийн музейн гол үзмэрийн нэг болж байна. Козловын энэ экспедицид дадлагажих оюутнаар ажиллаж байсан А.Симуков хожмоо нэртэй судлаач болж шинэ монгол улсын анхны газрын зургийн нэгийг үйлдсэн байдаг. 1921-1924 он бол монгол орон зөвлөлтийн тусламжаар тусгаар тогтнолоо зарласан боловч зарим нэг бодлогыг ялангуяа дотооддоо бие даан явуулдаг, хэмжээт эрхт хэмээн Богд эзэн хаан ширээндээ суусан хэвээр хүрээ болон бусад газарт Америк, Швед болон Хятад оросын пүүсүүд эрх тэгш үйл ажиллагаа явуулсан, Данийн фермерүүд хөдөө нутагт энэ төрлийн аж ахуй байгуулах туршилт хийж байсан зурвас үе юм.

Р.Эндрюсийн экспедиц тэр жилээ өнөөгийн Баянхонгор аймгийн нутаг Бөөнцагаан нуур, Өөшийн нуруу, Луугийн худаг, Арц богд, Баян заг зэрэг газар малтлага хийж хирс маягийн аварга гүрвэл (*Baluchitherium*) тоть хошуут үлэг гүрвэл (*Psittacosaur protiguanoddon*) зэргийг олжээ. 1923 онд төв аймгийн гуравдугаар экспедицийнхэн дэлхийг шуугиулсан олдворыг Баянзагаас нээжээ. Тус экспедицийн палеонтологич Жорж Оулсоны олсон үлэг гүрвэлийн өндөг байв.

Энэ цаг мөчөөс хойш хүн төрөлхтөн үлэг гүрвэл өндөг гаргадаг байжээ гэдгийг мэдэж авсан юм. Энэ мэдлэг өнөөдөр сургуулийн бага дунд насныхны мэддэг зүйлсийн аймагт багтжээ. Мөн шүдгүй махан идэшт үлэг гүрвэлийг ч анх эндээс олж нээсэн байна. Овираптур (Oviraptor) нь шүдгүй боловч бусад үлэг гүрвэлийнхээ өндгийг хулгайлан иддэг амьтан байжээ.

1. Р.Эндрюсийн эксдидиц малтлага хийсний үр дүнд юуг нээсэн бэ? /10оноо/

.....
.....
.....
.....
.....

2. Цогт Бадамжав, Эндрюсийн III экспедицид ажиллах болсон шалтгаан юу вэ? /4 оноо/

.....
.....

3. Эхэд байгаа доорх үгстэй ойролцоо утгат үг хэллэгийг олно уу. /4 оноо/

Ширдэг -
Зарлах -

4. Дараах 3 энгийн өгүүлбэрийн байрыг сэлгэн холбож, холимог нийлмэл өгүүлбэр бүтээгээрэй. /4 оноо /

Хайр сэтгэлийг зөвхөн цэцэгсийн хэлээр л төгс илэрхийлж болдог. Хайрлаж дурлаж үзээгүй хүн тэр хэлийг эс мэднэ. Цэцгийн энэ нууц хэлийг мартахаараа хүн хайрлаж, дурлаж чадахаа больдог.

.....
.....
.....

5. Алдаатай үгийг засаж, ЗБДүрмээр тайлбарлаарай. /2оноо/

Зурагын-.....
.....

6. Алдаатай үгийг засаж, ЗБДүрмээр тайлбарлаарай./2оноо/

Барилдхааргүй-.....
.....

7. Эдип хаан юуны төлөө санаа зовсон тухай болон түүний шийдвэрийн талаар үзэл бодлоо бичнэ үү. Үзэл бодлоо илэрхийлэхдээ юунаас үндэслэснээ бичээрэй . /2оноо/

.....
.....
.....
.....

8. Б. Лхагвасүрэн “Боржгины бор тал” шүлэгт “Эхийн сүү тагнайд амтагдаж...” гэсэн нь ямар утгатай вэ? /2оноо/

А. Ээж минь үгүйлэн бодогдсон

